



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/22/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Баталгаат тооцоолол аудит ХХК, захирал М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaataudit.com Аудитын менежер: Г.Цогтбаатар Цахим хаяг: tsogtbaatar@batalgaataudit.com Ахлах аудитор: Н.Цэнгэнбаяр Цахим хаяг: tsengenbayar.n@batalgaataudit.com Аудитор: Ү.Батбаяр Цахим хаяг: batbayar@batalgaataudit.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	1
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 346
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА И.БАТЗАЯА
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 126 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 94 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасныг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга 91.0 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,898,847,193.60	5,735,541,307.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,642,702,558.56	99,633,703.28
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,642,702,558.56	99,633,703.28
3121	Төгрөг	1,642,702,558.56	99,633,703.28
31211	Төрийн сангийн харилцах	1,642,702,558.56	99,633,703.28
33	АВЛАГА	1,359,506,771.50	3,582,918,320.50
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,359,506,771.50	3,582,269,220.50
335	Бусад авлага		649,100.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		649,100.00
34	УРЬДЧИЛГАА	4,110,387.00	22,247,887.00
346	Урьдчилж гарсан зардал	4,110,387.00	22,247,887.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,892,527,476.54	2,030,741,396.26
351	Түүхий эд материал	1,436,327,632.97	1,407,992,796.75
3513	Эм боох материал	1,436,327,632.97	1,407,992,796.75
354	Хангамжийн материал	456,199,843.57	622,748,599.51
3541	Бичиг хэргийн материал	4,326,450.00	4,161,800.00
3542	Аж ахуйн материал	43,324,453.06	39,646,295.06
3544	Түлш, шатах тослох материал	7,107,208.42	2,858,436.38
3546	Хүнсний материал	14,000.00	
3547	Бусад хангамжийн материал	401,427,732.09	576,082,068.07
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,427,082,319.60	14,433,360,327.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,427,082,319.60	14,433,360,327.16
392	Биет хөрөнгө	9,227,874,509.64	14,235,855,142.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,834,074,825.29	8,763,317,834.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-428,532,516.85	-566,461,107.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	301,486,434.00	395,576,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-63,706,298.31	-89,981,005.59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,202,881,806.00	9,179,568,637.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,352,193,265.33	-4,337,846,314.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	986,089,702.40	1,212,151,882.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-252,226,177.56	-320,471,217.81
393	Биет бус хөрөнгө	199,207,809.96	197,505,184.92
39301	Програм хангамж	5,464,500.00	5,464,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,884,250.04	-3,586,875.08
39303	Бусад биет бус хөрөнгө	195,627,560.00	195,627,560.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,325,929,513.20	20,168,901,634.20
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,279,381,721.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,279,381,721.05
413	Өглөг		1,279,381,721.05
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		186,582,603.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,092,799,118.05
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,325,929,513.20	18,889,519,913.15

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	14,325,929,513.20	18,889,519,913.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,086,682,501.36	3,086,682,501.36
51101	Өмч: - төрийн	3,086,682,501.36	3,086,682,501.36
512	Хуримтлагдсан үр дүн	9,595,481,755.70	15,802,837,411.79
5121	Өмнөх үеийн үр дүн	9,595,481,755.70	9,595,481,755.70
5122	Тайлант үеийн үр дүн		4,563,590,399.95
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,643,765,256.14	1,643,765,256.14
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,325,929,513.20	20,168,901,634.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,682,854,201.68	27,700,009,507.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,682,854,201.68	8,507,897,306.01
120	Нийтлэг татварын бус орлого	2,634,886,611.58	8,507,897,306.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,634,886,611.58	892,980,676.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	441,164,393.00	759,714,826.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	551,019,660.02	133,265,850.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	1,642,702,558.56	
120009	Бусад орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		5,068,467,086.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		2,546,449,542.79
122	Тусламжийн орлого	13,047,967,590.10	
122001	Хандив тусламж /дотоод/	13,047,967,590.10	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		19,192,112,201.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		19,192,112,201.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		19,192,112,201.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	18,192,293,376.85	23,136,419,107.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,192,293,376.85	23,136,419,107.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,985,210,092.85	23,081,811,107.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,511,919,679.10	10,193,241,656.00
210101	Үндсэн цалин	4,027,937,355.43	6,493,859,836.00
210102	Нэмэгдэл	1,411,883,142.67	1,895,346,085.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	502,522,000.00	766,849,259.00
210104	Урамшуулал	589,577,181.00	1,037,186,476.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	810,705,665.00	1,263,289,348.00
210201	Тэтгэврийн даатгал	566,384,658.12	880,385,920.79
210202	Тэтгэмжийн даатгал	66,633,476.12	103,574,812.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	52,117,339.03	81,434,249.96
210204	Ажилгүйдлийн даатгал	11,352,014.89	17,843,633.53
210205	Эрүүл мэндийн даатгал	114,218,176.84	180,050,731.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,174,972.31	392,767,314.05
210301	Гэрэл, цахилгаан	166,307,701.00	228,893,942.78
210302	Түлш, халаалт	68,946,070.31	66,463,255.52
210303	Цэвэр, бохир ус	61,921,201.00	97,410,115.75

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	1,640,992,520.23	672,575,492.58
210401	Бичиг хэрэг	61,679,152.00	97,700,660.00
210402	Тээвэр, шатахуун	31,875,428.06	29,403,472.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,402,991.06	20,813,041.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	63,875,255.00	36,903,604.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	157,883,084.06	166,501,623.75
210408	Бараа материал акталсны зардал	1,304,276,610.05	321,253,091.71
2105	Нормативт зардал	4,635,747,296.32	5,161,992,441.62
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,594,684,096.32	5,158,450,441.62
210502	Хоол, хүнс	41,063,200.00	3,542,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,082,289.94	100,855,128.97
210604	Урсгал засвар	112,082,289.94	100,855,128.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,838,118,670.90	4,020,716,245.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,813,909,802.90	3,970,456,370.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,500,000.00	5,450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		670,410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	491,007.00	508,815.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,220,000.00	30,129,600.00
210807	Газрын төлбөр	1,292,281.00	1,441,470.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		6,692,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,705,580.00	5,268,180.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,138,468,999.05	1,276,373,480.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	779,087,634.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,477,002.00	122,119,169.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,313,904,363.05	1,154,254,311.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,083,284.00	54,608,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,083,284.00	54,608,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	175,253,100.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,830,184.00	54,608,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-2,509,439,175.17	4,563,590,399.95
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	783,626,360.26	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	159,009,492.86	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	624,616,867.40	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-783,626,360.26	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,293,065,535.43	4,563,590,399.95

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	15,745,505,345.02	17,862,930,428.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,745,505,345.02	893,580,676.82
120	Нийтлэг татварын бус орлого	992,525,268.02	893,580,676.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	992,525,268.02	892,980,676.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	441,164,393.00	759,714,826.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	551,360,875.02	133,265,850.00
120009	Бусад орлого		600,000.00

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

122	Тусламжийн орлого	14,752,980,077.00	
122001	Хандив тусламж /дотоод/	14,752,980,077.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		16,969,349,752.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		16,969,349,752.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		16,969,349,752.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	14,121,165,411.48	18,313,934,051.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,121,165,411.48	18,313,934,051.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,914,082,127.48	18,259,326,051.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,511,919,679.10	10,008,012,353.00
210101	Үндсэн цалин	4,027,937,355.43	6,310,401,011.00
210102	Нэмэгдэл	1,411,883,142.67	1,893,721,550.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	502,522,000.00	766,849,259.00
210104	Урамшуулал	569,577,181.00	1,037,040,533.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	810,705,665.00	1,263,185,148.00
210201	Тэтгэврийн даатгал	566,384,658.12	880,315,064.79
210202	Тэтгэмжийн даатгал	66,633,476.12	103,566,476.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	52,117,339.03	81,427,581.16
210204	Ажилгүйдлийн даатгал	11,352,014.89	17,841,966.33
210205	Эрүүл мэндийн даатгал	114,218,176.84	180,034,059.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	309,209,633.31	392,767,314.05
210301	Гэрэл, цахилгаан	178,342,362.00	228,893,942.78
210302	Түлш, халаалт	68,946,070.31	66,463,255.52
210303	Цэвэр, бохир ус	61,921,201.00	97,410,115.75
2104	Хангамж, бараа материалын зардал	162,271,985.06	186,128,105.08
210401	Бичиг хэрэг	25,125,610.00	46,850,810.00
210402	Тээвэр, шатахуун	33,963,200.00	24,926,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,494,995.06	20,813,041.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,681,730.00	37,746,554.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,006,450.00	55,791,000.00
2105	Нормативт зардал	2,842,271,389.00	2,031,451,942.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,737,941,189.00	1,929,288,442.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	104,330,200.00	102,163,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,808,690.00	182,382,876.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,330,500.00	54,484,708.00
210602	Тавилга	1,132,000.00	
210604	Урсгал засвар	110,346,190.00	127,898,168.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,880,360,820.00	4,066,671,645.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,820,146,760.00	3,976,684,370.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,000,000.00	5,450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		670,410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	491,007.00	508,815.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,820,000.00	30,129,600.00
210807	Газрын төлбөр	1,292,281.00	1,441,470.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		6,692,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	39,610,772.00	44,995,580.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,259,534,266.01	128,726,667.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,172,071,264.01	135,000.00

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	87,463,002.00	128,591,667.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,083,284.00	54,608,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,083,284.00	54,608,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	175,253,100.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,830,184.00	54,608,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,624,339,933.54	-451,003,622.28
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,862,250.00	1,092,065,233.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	10,862,250.00	1,092,065,233.00
	Дотоод эх үүсвэрээр	10,862,250.00	1,092,065,233.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,862,250.00	1,092,065,233.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,862,250.00	-1,092,065,233.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,613,477,683.54	-1,543,068,855.28
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,642,702,558.56
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		99,633,703.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,086,682,501.36	1,775,530,319.38	6,382,846,101.61	11,245,058,922.35
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			131,765,063.24	131,765,063.24
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,086,682,501.36	1,775,530,319.38		
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-131,765,063.24		-131,765,063.24
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			3,080,870,590.85	3,080,870,590.85
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,086,682,501.36	1,643,765,256.14	9,595,481,755.70	14,325,929,513.20
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,455,310.00	1,455,310.00
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-1,455,310.00		-1,455,310.00
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			4,563,590,399.95	4,563,590,399.95

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

19	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,086,682,501.36	1,642,309,946.14	14,168,067,854.99	18,889,519,913.15
----	--	------------------	------------------	-------------------	-------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,528,895,500.00	19,405,999,284.10	122,896,215.90	99.4%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,528,895,500.00	19,405,999,284.10	122,896,215.90	99.4%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,460,395,500.00	19,351,391,284.10	109,004,215.90	99.4%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,034,445,300.00	10,008,012,353.00	26,432,947.00	99.7%
210101	Үндсэн цалин	6,909,347,000.00	6,310,401,011.00	598,945,989.00	91.3%
210102	Нэмэгдэл	1,590,365,000.00	1,893,721,550.00	-303,356,550.00	119.1%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	739,144,000.00	766,849,259.00	-27,705,259.00	103.7%
210104	Урамшуулал	795,589,300.00	1,037,040,533.00	-241,451,233.00	130.3%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,310,084,400.00	1,263,185,148.00	46,899,252.00	96.4%
210201	Тэтгэврийн даатгал	955,021,900.00	880,315,064.79	74,706,835.21	92.2%
210202	Тэтгэмжийн даатгал	90,063,500.00	103,566,476.59	-13,502,976.59	115.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	70,633,400.00	81,427,581.16	-10,794,181.16	115.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	17,669,600.00	17,841,966.33	-172,366.33	101.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	176,696,000.00	180,034,059.13	-3,338,059.13	101.9%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	407,750,000.00	392,767,314.05	14,982,685.95	96.3%
210301	Гэрэл, цахилгаан	240,250,000.00	228,893,942.78	11,356,057.22	95.3%
210302	Түлш, халаалт	67,000,000.00	66,463,255.52	536,744.48	99.2%
210303	Цэвэр, бохир ус	100,500,000.00	97,410,115.75	3,089,884.25	96.9%
2104	Хангамж, бараа материалын зардал	199,276,100.00	186,128,105.08	13,147,994.92	93.4%
210401	Бичиг хэрэг	53,000,000.00	46,850,810.00	6,149,190.00	88.4%
210402	Тээвэр, шатахуун	24,930,000.00	24,926,700.00	3,300.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,000,000.00	20,813,041.08	2,186,958.92	90.5%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,900,000.00	37,746,554.00	3,153,446.00	92.3%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	57,446,100.00	55,791,000.00	1,655,100.00	97.1%
2105	Нормативт зардал	2,451,887,300.00	2,031,451,942.00	420,435,358.00	82.9%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,349,723,800.00	1,929,288,442.00	420,435,358.00	82.1%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	102,163,500.00	102,163,500.00	0.00	100.0%

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,203,364,200.00	1,274,448,109.97	-71,083,909.97	105.9%
210601	Багаж, техник, хэрэгсэл	530,400,500.00	594,616,867.00	-64,216,367.00	112.1%
210602	Тавилга	232,869,600.00	232,869,588.00	12.00	100.0%
210604	Урсгал засвар	440,094,100.00	446,961,654.97	-6,867,554.97	101.6%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,671,759,000.00	4,066,671,645.00	-394,912,645.00	110.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,576,016,900.00	3,976,684,370.00	-400,667,470.00	111.2%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,330,000.00	5,450,000.00	880,000.00	86.1%
210803	Даатгалын үйлчилгээ	670,400.00	670,410.00	-10.00	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	508,800.00	508,815.00	-15.00	100.0%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00	0.00	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,000,000.00	30,129,600.00	4,870,400.00	86.1%
210807	Газрын төлбөр	1,441,500.00	1,441,470.00	30.00	100.0%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,692,400.00	6,692,400.00	0.00	100.0%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	45,000,000.00	44,995,580.00	4,420.00	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	181,829,200.00	128,726,667.00	53,102,533.00	70.8%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	135,000.00	135,000.00	0.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	181,694,200.00	128,591,667.00	53,102,533.00	70.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,500,000.00	54,608,000.00	13,892,000.00	79.7%
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,500,000.00	54,608,000.00	13,892,000.00	79.7%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	68,500,000.00	54,608,000.00	13,892,000.00	79.7%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,528,895,500.00	17,862,930,428.82	1,665,965,071.18	91.5%
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,851,679,700.00	16,969,349,752.00	16,969,349,752.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,851,679,700.00	16,969,349,752.00	-117,670,052.00	100.7%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,677,215,800.00	892,980,676.82	1,784,235,123.18	33.4%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	892,346,600.00	759,714,826.82	132,631,773.18	85.1%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,166,600.00	133,265,850.00	8,900,750.00	93.7%
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,642,702,600.00	1,642,702,600.00	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,642,702,558.56	-1,642,702,558.56	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		99,633,703.28	-99,633,703.28	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэл нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах эрүүл мэндийг дэмжих хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийг дэмжих, хамгаалах өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулах, эрүүл мэндийн талаар төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомж, тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэх амбулатори болон хэвтүүлэн эмчлэх эмнэлэг, лабораторийн үйл ажиллагаа явуулдаг.

Тус эмнэлэг нь “Ур чадварт суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх, эмнэлгийн орчныг боловсронгуй болгох, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох замаар хүн амын эрүүл мэндийг дэмжих” зорилго тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа , санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоол “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай”
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” /2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс/

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг , түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах , дотоод аудитроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Адвэнсэд адвайсори ХХК-тай 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн А/36/2022 дугаар гэрээгээр хийж гүйцэтгүүлсэн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байгаа боловч тушаал шийдвэр гаргаж баталгаажуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого , толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,842,972.1 мянган төгрөгөөр буюу 40.7 хувиар өссөн байна.

Хүснэгт1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,642,702.6	99,633.7	-1,543,068.9
Авлага	1,359,506.8	3,582,918.3	2,223,411.5
Урьдчилгаа	4,110.4	22,247.9	18,137.5
Бараа материал	1,892,527.5	2,030,741.4	138,213.9
Үндсэн хөрөнгө	9,427,082.3	14,433,360.3	5,006,278.0
Нийт хөрөнгө	14,325,929.5	20,168,901.6	5,842,972.1
Өр төлбөр	0.0	1,279,381.7	1,279,381.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,325,929.5	18,889,519.9	4,563,590.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,325,929.5	20,168,901.6	5,842,972.1

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 99,633.7 мянган төгрөг болж 1,543,068.9 мянган төгрөгөөр буурсан нь эм, эмнэлэгийн хэрэгслийн материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 3,582,918,3 мянган төгрөг болж 2,223,411.5 мянган төгрөгөөр өссөн нь төлбөртэй үйлчилгээний авлага болох ЭМДЕГ-аас авах санхүүжилт ороогүйтэй холбоотой. Авлагын дансны үлдэгдэлд хугацаа хэтэрсэн авлагагүй ба тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Бараа материал 138,213.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан хангамжийн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 14,433,360.3 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 5,006,278.0 мянган төгрөг буюу 53.1 хувиар өссөн нь тайлант онд урсгал төсвийн худалдан авалтаар 1,092,065.2 мянга, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5,068,467.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдэж, 934,450.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,279,381.7 мянган төгрөг байгаа нь эмийн өглөг 1,091,799.1 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 185,906.8 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 75.8 мянган төгрөг, ажилтан албан хаагчдад өгөх өглөг 600.0 мянган төгрөг, урсгал засварын өглөг 1,000.0 мянган төгрөг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт , гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх , хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага , төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 27,980,323.4 мянга, үйл ажиллагааны орлогоос 600,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 28,589,323.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 9,060,427.9 мянган төгрөгөөр бууруулж 19,528,895.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 16,851,679.7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,034,513.2 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 1,642,702.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 16,969,349.7 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 892,980.7 мянган төгрөг урьд оны үлдэгдлээс 1,642,702.6 мянган төгрөгийг бүрдүүлж үйл ажиллагаандаа нийт 19,405,999.3 мянган төгрөгийг зарцуулж 99,033.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 19,405,999.3 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 54,708.2 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардлыг 452.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 13,892.0 мянган төгрөгөөр, олон улсын байгууллагаас олгосон тусламж үйлчилгээний санхүүжилтыг 53,782.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төсөв	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				зөрүү	биелэлт
	71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ	19,528,895.5	19,405,999.3	-122,896.2	99.4%
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	19,178,110.4	19,123,402.2	-54,708.2	99.7%
2	80219-Харуул хамгаалалтын зардал	96,658.8	96,206.3	-452.6	99.5%
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	68,500.0	54,608.0	-13,892.0	79.7%
4	83601-Нэмэлт олон улсын байгууллагаас олгосон	149,119.0	95,336.5	-53,782.5	63.9%
5	83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан	36,507.3	36,446.3	-61.0	99.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудиын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, Ү.Батбаяр нар гүйцэтгэж, чанарын менежер Г.Цогтбаатар, захирал М.Буянбулган нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2024 оны 2 дугаар сарын 02-ний өдрийн 79 дугаар албан бичгээр хуулийн хугацааг 7 хоног хоцроож ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийн нийт зардлаар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн нийт зардал болох 16,239,179.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 260,284.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд: тогтмол зардлыг 14,982.7 мянга, хангамж бараа материалын зардлыг 13,148.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэгстандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 18 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээших үнийн дүн бүхий зарлагын 1,178,251.3 мянган төгрөгийн 35 гүйлгээг, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 14 шийдвэрийг мэдээлээгүй нь "Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"; 6.4.8 "... бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-ийг мэдээллэх:" заалтыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж ажиллах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 1,092,065.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 3,373,120.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Байгууллагын ойг угтсан арга хэмжээнд цуврал баримтат кино хийлгэсний төлбөрт 16,500.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" заалтыг мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж цуврал баримтат киног нэмж хийхгүй байх зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 10,645.6 мянган төгрөгийн алдааг илрүүлж санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,825,225.2 мянган төгрөгийн албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1,825,225.2	1	1,825,225.2	100%
Зөвлөмж	2	-	2	-	100%
Нийт дүн	3	1,825,225.2	3	1,825,225.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн нэхэмжлэлийн алдаа, зөрчил гарч байгаа болон салбарын хэмжээнд мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт нь стандарт болон байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч буй эсэх.
- Албан хаагчдын илүү цагийн хөлсийг тооцохдоо өмнөх саруудын нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцогдсон цагийн дунджаар давхардуулан олгосон асуудалд анхаарал хандуулах шаардлагатай

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 6,940.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 6,940.4 мянган төгрөгийн зардал дутуу илэрхийлсэн.

Аудитаар нийт 150,541.2 мянган төгрөгийн зөрчил² илэрч дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Төлбөрийн баримтын цахим системд өөрийн үйл ажиллагааны орлогыг бүртгээгүй, үйлчлүүлэгчид 150,541.2 мянган төгрөгийн цахим и баримт олгоогүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2. “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.3.3. “хэрэглэгчийн системд бүртгэгдсэн төлбөрийн баримтын мэдээллийг гурав хоногийн дотор багтаан борлуулалтын нэгдсэн системд илгээнэ” заалтуудыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Өөрийн үйл ажиллагааны орлогод цахим төлбөрийн баримтыг үйлчлүүлэгчдэд тухай бүр олгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Байгууллага нь цалингийн тодорхой журамгүй, нэмэгдэл хөлс тооцож дүгнэсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн баримтын бүрдэл дутуу, цагийн дундаж ажлын хөлсийг тооцохдоо цалингийн нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг оруулан тооцож байгаа нь цалингийн нэмэгдэл давхардуулан олгогдох нөхцөл үүсч байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3. “жинхэнэ хэрэгжилтийн” 5.1.4. “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;” заалтыг мөрдөж ажиллагаагүй.

Шийдвэрлэсэн нь: Цалин хөлстэй холбоотой дотоод журмыг шинэчлэн мөрдөх, илүү цагийн норм, нормативийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		НББ-ийн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд зардал дутуу илэрхийлсэн.	1	6,940.4	1	6,940.4			1	6,940.4				
Дүн	1	6,940.4	1	6,940.4			1	6,940.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өөрийн үйл ажиллагааны орлогод цахим и баримтыг олгоогүй.	1	150,541.2					1	150,541.2				
Цалингийн тогтсон журамгүй.	1	-					1	-				
Дүн	2	150,541.2					2	150,541.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим 35 гүйлгээг, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 14 шийдвэрийг мэдээлээгүй	1	1,178,251.3						1	1,178,251.3
Дүн	1	1,178,251.3						1	1,178,251.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Байгууллагын ойг угтсан арга хэмжээнд цуврал баримтат кино хийлгэсэн.	1	16,500.0						1	16,500.0

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дүн	1	16,500.0					1	16,500.0
Нийт дүн	2	1,194,751.3					2	1,194,751.3

Аудитын тайланг хянасан:

Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн захирал



М.Буянбулган

Чанарын хяналтын менежер



Г.Цогбаатар

Бэлтгэсэн:

Ахлах аудитор



Н.Цэнгэнбаяр